



**НИЙСЛЭЛИЙН
БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 05 сарын 14 өдөр

Дугаар А/20

Улаанбаатар хот

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/546 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Сагсан бөмбөгийн спортыг хөгжүүлэх, олимпын эрх олгох, нийслэл хотоо дэлхийн улс орнуудад сурталчлах зорилгоор “Улаанбаатар Урбан фестиваль” сагсан бөмбөгийн 3x3 олон улсын тэмцээнийг 2024 оны 06 дугаар сарын 04-10-ны өдрүүдэд зохион байгуулахад дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дэмжлэг үзүүлэхэд шаардагдах 990,000,000 (есөн зуун ерэн сая) төгрөгийг “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, нийслэлийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөөг хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ”-ний зардлаас гаргахыг нягтлан бодогч (П.Ариунцэцэг)-д зөвшөөрсүгэй.

3.Тэмцээнд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэн, нэгдсэн удирдлагаар хангаж хамтран ажиллахыг Спорт, нийтийн биеийн тамирын хэлтэс (С.Саранцэцэг)-т үүрэг болгосугай.

